

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2023.04.28

## 1.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс Эрдэнэсант суманд "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгөөр иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж, сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллалаа.



## 2.Хяналт шалгалтын чиглэлээр:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 19 өргөдөл, гомдол, 17 албан бичгийг хүлээн авч 17 өргөдөл, 15 албан бичигт хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар иргэний нэхэмжлэлтэй шүүх хуралд хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 1 удаа нийгмийн даатгалын хэлтсийг төлөөлж гуравдагч этгээдийн үүргээр татагдан оролцож иргэнд талд шийдвэр гаргуулж ажилласан.

## 2.ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа 33 цаг хуралдаж, нийт 240 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 201 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 14 иргэнийг цуцалж, 2 иргэн буцаасан байна.

## 3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хамтран ажиллах гэрээний дагуу Хаан, Төрийн банкаар 17936 тэтгэвэр авагчдад 8,9 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгосон.

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС